



БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Бүрэгхангай сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БУА-2023/20/-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Булган аймаг 2023 он	Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Б.Эрдэнэ Утас:70342580 Цахим хаяг: Erdene.B@audit.local Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас: 70342716 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn Аудитор: Б.Энхтөр Утас: 70342716 Цахим хаяг: Enkhturb@audit.gov.mn
-----------------------------------------------------------------------------------------	-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
 3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
 4. Аудитын тайлан
 - 4.1 Ерөнхий зүйл
 - 4.2 Материаллаг байдал
 - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
 - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал
5. Аудитын илрүүлэлт
 6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



БУЛГАН АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс: 7034-2580
E-mail: bulgan@audit.gov.mn

2022.02.24 № 208
танай _____ ны № _____ т

БУЛГАН АЙМГИЙН БҮРЭГХАНГАЙ
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Ц.МӨНХТУЛГА ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Бүрэгхангай сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Засаг даргын Тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

“Хожуул, унанги гишүү” төслийг 1 жилийн хугацаатай 5 бүлийг сонгож гэрээ байгуулан нийт 25.0 сая төгрөгийн санхүүжилттэй 95.1 га талбайд байгаль орчны ойн цэвэрлэгээ, шинэ ажлын байр бий болгох, босоо мод унагаахаас сэргийлэх, иргэдэд хэрэглээний модыг бэлтгэн нийлүүлэх зорилготойгоор тус төслийг 2021-2022 онд хэрэгжүүлэхээр төлөвлөж 2022 онд тус төсөлд 5 бүл оролцож гэрээгээр нэг бүлд 5.0 сая төгрөгийн санхүүжилт олгох байсан боловч Байгаль хамгаалах сангаас санхүүжилт нь 15.0 сая төгрөгөөр тавиглаж 1 бүлд 3.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

Аудитын гол асуудал

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлуудыг үздэг. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

006020071

Бусад асуудлын хэсэг

Батлагдсан төсвийн хүрээнд байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөгөөр 2022 онд 51 зорилтын хүрээнд 86 ажил төлөвлөж гүйцэтгэлийн биелэлт 95.2 хувьтай дүгнэгджээ.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.ЭРДЭНЭ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

СТ-1А

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	39,991,337.00	48,450,744.00
33	АВЛАГА	6,680,037.00	16,275,344.00
335	Бусад авлага	6,680,037.00	16,275,344.00
3351	Байгууллагаас авах авлага	5,582,593.00	15,177,900.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	1,097,444.00	1,097,444.00
35	БАРАА МАТЕРИАЛ	3,423,300.00	1,201,400.00
354	Хангамжийн материал	3,423,300.00	1,201,400.00
35410	Бичиг хэргийн материал	142,500.00	431,400.00
35420	Аж ахуйн материал	1,260,800.00	770,000.00
36	НӨӨЦИЙН БАРАА	29,888,000.00	30,974,000.00
36300	Тэжээлийн нөөц	26,888,000.00	27,974,000.00
36500	Буудайн нөөц	3,000,000.00	3,000,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,537,660,073.27	4,216,645,528.74
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,537,660,073.27	4,216,645,528.74
392	Биет хөрөнгө	3,519,567,573.27	4,200,178,028.78
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,565,453,957.58	3,155,148,890.58
39202	Хуримтлагдсан элэгдэл	(483,116,210.96)	(614,089,098.30)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	247,703,313.00	206,279,515.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(187,790,660.17)	(159,474,392.60)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	570,685,472.67	637,054,872.67
39206	Хуримтлагдсан элэгдэл	(162,523,502.06)	(210,374,402.43)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	35,527,936.77	29,047,845.61
39208	Хуримтлагдсан элэгдэл	(20,411,470.68)	(19,861,086.36)
39209	Зам, гүүрийн байгууламж	845,832,704.00	850,832,704.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	(99,390,309.00)	(153,580,905.42)
39214	Бусад үндсэн хөрөнгө	278,393,890.00	576,393,890.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(70,797,547.88)	(97,199,803.97)
393	Биет бус хөрөнгө	18,092,500.00	16,467,499.96
39301	Програм хангамж	7,600,000.00	7,600,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(137,500.00)	(1,762,500.04)
39303	Бусад биет бус хөрөнгө	10,630,000.00	10,630,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	3,577,651,410.27	4,265,096,272.74
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	3,785,379.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	3,785,379.00
413	Өглөг	-	3,785,379.00
4136	Бусад өглөг	-	3,785,379.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	3,785,379.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,577,651,410.27	4,261,310,893.74
51	Засгийн газрын хувь оролцоо	3,577,651,410.27	4,261,310,893.74
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,009,553,754.60	1,009,553,754.60
51101	Өмч: - төрийн	1,009,553,754.60	1,009,553,754.60
512	Хуримтлагдсан үр дүн	1,702,404,858.53	2,386,064,342.00
51210	Өмнөх үеийн үр дүн	1,702,404,858.53	1,702,404,858.53
51220	Тайлант үеийн үр дүн	-	683,659,483.47

51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	865,692,797.14	865,692,797.14
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	3,577,651,410.27	4,265,096,272.74

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

СТ-2А

САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл /Төгрөгөөр/
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,530,340,842.00	1,684,460,725.40
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	542,870,667.00	706,479,157.00
120	Нийтлэг татварын бус орлого	540,870,667.00	706,479,157.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	88,516,000.00	2,450,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	2,450,000.00
120009	Бусад орлого	452,354,667.00	704,029,157.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	987,470,175.00	977,981,568.40
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	236,570,475.00	226,896,568.40
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	205,598,790.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	186,617,375.00	6,244,877.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	49,953,100.00	15,052,901.40
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	750,899,700.00	751,085,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	750,899,700.00	751,085,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,221,028,426.83	994,310,216.70
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,195,528,426.83	994,310,216.70
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	866,314,300.63	919,054,532.33
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	235,957,035.00	241,775,714.00
210101	Үндсэн цалин	170,530,435.00	179,180,571.00
210102	Нэмэгдэл	52,951,104.00	44,049,943.00
210104	Урамшуулал	-	7,504,362.00
210105	Гэрээт ажлын хөлс	12,475,496.00	11,040,838.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,214,200.80	31,252,810.02
210201	Тэтгэврийн даатгал	21,831,653.60	21,559,626.12
210202	Тэтгэмжийн даатгал	2,402,027.66	2,436,928.13
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,867,953.61	1,949,442.53
210204	Ажилгүйдлийн даатгал	753,422.37	487,385.60
210205	Эрүүл мэндийн даатгал	4,359,143.56	4,819,427.64
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	48,048,486.00	52,410,890.01
210301	Гэрэл, цахилгаан	10,939,218.00	13,550,765.01
210302	Түлш, халаалт	37,109,268.00	38,860,125.00

2104	Хангамж, бараа материалын зардал	33,114,773.00	27,684,370.00
210401	Бичиг хэрэг	4,185,990.00	4,019,150.00
210402	Тээвэр, шатахуун	11,827,030.00	19,291,730.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,415,480.00	1,938,040.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	647,600.00	1,608,750.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	665,100.00	826,700.00
2105	Нормативт зардал	440,000.00	800,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	440,000.00	800,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,237,145.00	20,260,076.00
210604	Урсгал засвар	7,237,145.00	20,260,076.00
2107	Томилолт, зочны зардал	2,032,000.00	4,212,000.00
210702	Дотоод албан томилолт	2,032,000.00	4,212,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,533,967.00	18,243,300.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	810,000.00	17,580,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	267,522.00	300,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	356,445.00	363,300.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	504,736,693.83	522,415,372.30
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	265,549,542.00	238,478,220.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	650,000.00	997,400.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	238,537,151.83	282,939,752.30
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	329,214,126.20	75,255,684.37
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	16,337,600.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	-	15,837,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	500,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	329,153,496.20	58,918,084.37
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	329,153,496.20	58,918,084.37
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	309,312,415.17	690,150,508.70
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	76,032,000.00	6,491,025.23
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	487,025.23
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	76,032,000.00	6,004,000.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(76,032,000.00)	(6,491,025.23)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	233,280,415.17	683,659,483.47

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

СТ-2А

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
------------	----------	---------------------	-----------------------

1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	997,387,285.00	983,564,161.40
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	996,059,285.00	983,564,161.40
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	245,159,585.00	232,479,161.40
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	205,598,790.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	197,025,835.00	6,244,877.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	48,133,750.00	20,635,494.40
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	750,899,700.00	751,085,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	750,899,700.00	751,085,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	954,402,895.00	728,966,464.40
21	УРСГАЛ ЗАРДАЛ	954,402,895.00	728,966,464.40
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	619,606,175.80	638,532,880.03
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	235,957,035.00	241,907,239.88
210101	Үндсэн цалин	169,824,352.00	179,009,096.88
210102	Нэмэгдэл	52,315,416.00	44,308,551.00
210104	Урамшуулал	-	7,504,362.00
210105	Гэрээт ажлын хөлс	13,817,267.00	11,085,230.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,214,200.80	31,121,284.14
210201	Тэтгэврийн даатгал	21,792,423.78	21,472,045.08
210202	Тэтгэмжийн даатгал	2,409,873.27	2,425,991.92
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,899,337.66	1,940,613.55
210204	Ажилгүйдлийн даатгал	464,320.69	485,278.37
210205	Эрүүл мэндийн даатгал	4,648,245.40	4,797,355.22
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	48,048,486.00	52,410,890.01
210301	Гэрэл, цахилгаан	10,939,218.00	13,550,765.01
210302	Түлш, халаалт	37,109,268.00	38,860,125.00
2104	Хангамж, бараа материалын зардал	20,196,100.00	18,627,430.00
210401	Бичиг хэрэг	3,171,040.00	4,129,650.00
210402	Тээвэр, шатахуун	13,002,080.00	9,712,130.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,415,480.00	1,938,040.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	607,600.00	2,347,710.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	999,900.00	499,900.00
2105	Нормативт зардал	800,000.00	800,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	800,000.00	800,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,333,145.00	21,292,076.00
210604	Урсгал засвар	6,333,145.00	21,292,076.00
2107	Томилолт, зочны зардал	2,032,000.00	4,212,000.00
210702	Дотоод албан томилолт	2,032,000.00	4,212,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,321,967.00	19,398,030.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,598,000.00	18,734,730.00
210803	Даатгалын үйлчилгээ	267,522.00	300,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	356,445.00	363,300.00

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	268,703,242.00	248,763,930.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	268,053,242.00	247,766,530.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	650,000.00	997,400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	334,796,719.20	90,433,584.37
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	16,337,600.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	-	15,837,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	500,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	334,736,089.20	74,095,984.37
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	334,736,089.20	74,095,984.37
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	42,984,390.00	254,597,697.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	45,084,390.00	254,597,697.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	45,084,390.00	254,597,697.00
2200	Дотоод эх үүсвэрээр	45,084,390.00	254,597,697.00
222001	Тоног төхөөрөмж	4,237,500.00	59,199,300.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	11,999,890.00	195,398,397.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(45,084,390.00)	(254,597,697.00)

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

СТ-4А

ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	721,053,754.60	865,692,797.14	1,732,024,442.69	3,318,770,994.43
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	721,053,754.60	865,692,797.14	1,732,024,442.69	3,318,770,994.43
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	258,880,415.84	258,880,415.84
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	721,053,754.60	865,692,797.14	1,990,904,858.53	3,577,651,410.27
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	721,053,754.60	865,692,797.14	1,990,904,858.53	3,577,651,410.27
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	721,053,754.60	865,692,797.14	1,990,904,858.53	3,577,651,410.27
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	683,659,483.47	683,659,483.47
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	721,053,754.60	865,692,797.14	2,674,564,342.00	4,261,310,893.74

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ТГ

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	762553600.00	692211261.03
21	УРСГАЛ ЗАРДАЛ	533314300.00	437613564.03
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	516976700.00	421275964.03
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	247038800.00	240203439.88
210101	Үндсэн цалин	189996700.00	177305296.88
210102	Нэмэгдэл	43909000.00	44308551.00
210104	Урамшуулал	1250000.00	7504362.00
210105	Гэрээт ажлын хөлс	11883100.00	11085230.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31227500.00	30946284.14
210201	Тэтгэврийн даатгал	21475000.00	21297045.08
210202	Тэтгэмжийн даатгал	2437900.00	2425991.92
210203	ҮОМШӨ-ний даатгал	1950500.00	1940613.55
210204	Ажилгүйдлийн даатгал	487900.00	485278.37
210205	Эрүүл мэндийн даатгал	4876200.00	4797355.22
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	52568100.00	50410890.01
210301	Гэрэл, цахилгаан	14500000.00	11550765.01
210302	Түлш, халаалт	38068100.00	38860125.00
2104	Хангамж, бараа материалын зардал	19638900.00	16980030.00
210401	Бичиг хэрэг	3922100.00	3919650.00
210402	Тээвэр, шатахуун	8306800.00	8304730.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,910,000.00	1,908,040.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	5,000,000.00	2,347,710.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	500,000.00	499,900.00
2105	Нормативт зардал	800,000.00	800,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	800,000.00	800,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	36,300,000.00	18,375,880.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	18,000,000.00	-
210604	Урсгал засвар	18,300,000.00	18,375,880.00
2107	Томилолт, зочны зардал	6,070,000.00	4,212,000.00
210702	Дотоод албан томилолт	6,070,000.00	4,212,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	663,000.00	663,300.00
210803	Даатгалын үйлчилгээ	300,000.00	300,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	363,000.00	363,300.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	122,670,400.00	58,684,140.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	121,670,400.00	57,686,740.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,000,000.00	997,400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	16,337,600.00	16,337,600.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	16,337,600.00	16,337,600.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	15,837,600.00	15,837,600.00

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	500,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	229,239,300.00	254,597,697.00
2200	Дотоод эх үүсвэрээр	229,239,300.00	254,597,697.00
223001	Бусад хөрөнгө	229,239,300.00	195,398,397.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	751,085,600.00	751,085,000.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	751,085,600.00	751,085,000.00
132001	Орон нутгийн төсвөөс	751,085,600.00	751,085,000.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

НТ-2

НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	217,256,916.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	217,256,916.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	217,256,916.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,703,800.00
210101	Үндсэн цалин	1,703,800.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	175,000.00
210201	Тэтгэврийн даатгал	175,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,000,000.00
210301	Гэрэл, цахилгаан	2,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,647,400.00
210401	Бичиг хэрэг	210,000.00
210402	Тээвэр, шатахуун	1,407,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	30,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,001,196.00
210604	Урсгал засвар	3,001,196.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	18,734,730.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	18,734,730.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	189,994,790.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	189,994,790.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	226,896,568.40
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	226,896,568.40
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,080,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	207,763,667.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	15,052,901.40

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Урд бүсийн эдийн засгийн тулгуур төв болох эрхэм зорилготой. Иргэдийн сэтгэл ханамжид нийцсэн олон улсад өрсөлдөхүйц ажил, үйлчилгээ хамт олон, чадварлаг мэргэжилтэн, ёс зүй, хүндэтгэл, хариуцлага, харилцаа, хандлага Засаг даргын Тамгын газар үйл ажиллагаандаа Төрийн албаны үндсэн чиг үүрэгт уялдуулан чанарын менежментийн тогтолцоог хэрэгжүүлж тасралтгүй сайжруулж, олон улсын түвшний ажил үйлчилгээг үзүүлнэ гэсэн зорилготой.

Сумын Засаг даргын Тамгын газрын зорилт нь:

1. Цахим төрийн үйлчилгээг орон нутагт үр дүнтэй, хүртээмжтэй хэрэгжүүлэхэд бүх талын нөхцөл, боломжийг бүрдүүлж ажиллах

2. Төрийн байгууллагын үйл ажиллагааны мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлж, иргэд олон нийтийн оролцоог хангах
3. Төр, иргэний нийгмийн байгууллагын түншлэлийг бэхжүүлж, шийдвэр гаргах түвшинд иргэдийн оролцоог нэмэгдүүлж, зөв бодлогыг хэрэгжүүлэх
4. Төрийн албаны хүний нөөцийг үе шаттай сургаж, мэргэшүүлэн төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл боломжийг сайжруулж, төрийн үйлчилгээний үр дүн, үр нөлөөг дээшлүүлэх
5. Төрийн байгууллагад хандсан иргэдийн өргөдөл, гомдол, хүсэлтийг цахимаар хүлээн авч шуурхай шийдвэрлэх боломжийг бүрдүүлэх
6. Төрийн албаны хүний нөөцийн удирдлагын мэдээллийн санг цалингийн нэгдсэн системтэй холбож, орон тоо, цалин хөлсний зардлын төлөвлөлт, хэрэгжилт, хяналтыг сайжруулах
7. Төрийн бүх шатанд авлигаас урьдчилан сэргийлэх олон талт арга хэмжээнүүдийг зохион байгуулах
8. “Чанарын менежментийн тогтолцоо MNS ISO 9001:2016” олон улсын стандарт”-ыг нэвтрүүлэх, сайжруулах
9. Төрийн байгууллагын албан хаагчдыг гадаад болон дотооддоо туршлага судлах арга хэмжээнд хамруулах, тасралтгүй хөгжүүлэх
10. Төрийн байгууллагуудын архивын баримтын хадгалалт, хамгаалалтын нөхцөлийг сайжруулах, баримт бичгийн эмх цэгцийг төлөвшүүлэх
11. Иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх
12. Сумын гамшгийн эрсдэлийн үнэлгээ, тойм судалгааг холбогдох мэргэжлийн байгууллагаар хийлгэх, гамшгаас хамгаалах багаж, техник тоног төхөөрөмжийг сайжруулах

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Монгол улсын үндсэн хууль, Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Татварын тухай хууль, тогтоол шийдвэр, журмыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулж, хэрэгжилт нь үр нөлөөтэй байна.

Дотоод аудит/аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах /дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Бүрэгхангай сумын Засаг даргын Тамгын газар нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал/мөнгөн сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Бүрэгхангай сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 687.4 сая төгрөгөөр буюу 6. хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	0
Авлага	6,680,037	16,275,344	(9,595,307.00)
Бараа материал	33,311,300	32,175,400	1,135,900
Үндсэн хөрөнгө	3,537,660,073.27	4,216,645,528.74	(678,985,455.47)
Нийт хөрөнгө	3,577,651,410.27	4,265,096,272.74	(687,444,862.47)
Өр төлбөр	0	3,785,379.00	3,785,379.00
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	721,053,754.60	721,053,754.60	0
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	3,577,651,410.27	4,265,096,272.74	(687,444,862.47)

Дээрх хүснэгтээс харахад авлага 9,595.3, үндсэн хөрөнгө өмнөх оны үзүүлэлтээс 678.9 сая төгрөгөөр тус тус нэмэгджээ.

Үндсэн хөрөнгө, авлага нэмэгдсэн нь тавилга эд хогшлын шилжүүлсэн хөрөнгийн элэгдэлтэй холбогдон гарсан өөрчлөлт гэж тайлбарлаж байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Бүрэгхангай сумын Засаг даргын Тамгын газар нь тайлант хугацаанд орон нутгийн төсвөөс 715.7 сая төгрөгийн төсвийн саналыг хүргүүлж санал өгсөн дүнгээр баталж 657 сая төгрөгийг төсөвт байгууллагын үйл ажиллагаанд зарцуулан 58.8 сая төгрөгийг төвлөрүүлэн шилжүүлж ажилсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант хугацааны авлага 16.2 сая төгрөг болж өссөн нь 1995 оноос хойш эзэн холбогдогч нь тодорхойгүй олон жил он дамжсан авлага 1.1 сая төгрөг, цахим худгийн усны болон карт борлуулсан орлого 9.7 сая төгрөг, өвс тэжээл борлуулсан орлого 0.9 сая төгрөг, оны өмнө гүйлгээ хаахтай зэрэгцэн орж ирсэн отрын малчин өрхөд төрийн үйлчилгээг үзүүлэх дэмжлэг 1.5 сая төгрөг, сумын дотуур байрны өргөтгөлийн засварын зардалд 2.9 сая төгрөг, цахим тендерийн хураамжийн орлого 70.0 мянган төгрөг зэрэг санхүүжилтийн үлдэгдлээс шалтгаалж нэмэлт санхүүжилтийн дансанд авлага нэмэгдэн үүссэн байна.

Тайлант хугацаанд байгууллагад төлөх өглөг 3.8 сая төгрөгөөр өссөн нь ЗДТГ-ын дотоод засварын ажлын магадалшгүй ажиллагааны зардлын өглөг үүссэн.

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 9 хөтөлбөр арга хэмжээг хэрэгжүүлэхээр орон нутгийн төсвөөс 751.1 сая төгрөгийн санхүүжилтийг авч 692.2 сая төгрөгийг төсөвт байгууллагын үйл ажиллагаанд зарцуулан 58.8 сая төгрөгийг төвлөрүүлэн шилжүүлж ажилсан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Үйл ажиллагааны зардал /80101/	393,609.1	378,672.0	14,937.1	96.2
2	Баг хорооны үйл ажиллагааны зардал /80106/	52683.6	51397.9	1286,3	97.5
3	Нийтлэг үйлчилгээний зардал /80112/	14501.0	14501,0	0	100
4	Ажил олгогчооч олгох тэтгэмж /80802/	500,0	500,0	0	100
5	Сонгуулийн үр дүнгээр чөлөөлөгдсөн тэтгэмж /80815/	15837,6	15837,6	0	100

6	Бусад /80918/	229,239.3	195,398.3	33,841	85.2
7	Орон нутгийн нөөц хөрөнгө /80112/	35,000.0	29,312.6	5687,4	83.7
8	Хур хог хаягдал, орчны бохирдол /82212/	5000.0	1591.7	3408.3	32
9	Улсын баяр наадам /82801/	5000,0	5000,0	0	100

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтээр 226.8 сая төгрөгийн санхүүжилтийг авч зориулалтын дагуу зарцуулан ажиллаа.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

“Хожуул, унанги гишүү” төсөл хэрэгжих хугацаан нь гэрээгээр 1 жилийн хугацаатай нийт 25.0 сая төгрөгийн санхүүжилттэй 95.1 га талбайд байгаль орчны ойн цэвэрлэгээ, шинэ ажлын байр бий болгох, босоо мод унагаахаас сэргийлэх, иргэдэд хэрэглээний модыг бэлтгэн нийлүүлэх зорилготойгоор тус төслийн 2021-2022 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

2022 онд тус төсөлд 5 бүл оролцож гэрээгээр нэг бүлд 5.0 сая төгрөгийн санхүүжилт олгох байсан боловч Байгаль хамгаалах сангаас санхүүжилт нь 15.0 сая төгрөгөөр тавиглаж 5 бүлд 3.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/мянган төгрөгөөр/						
№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	“Хожуул, унанги гишүү” төсөл	1 жил	Байгаль орчны ойн цэвэрлэгээ, шинэ ажлын байр бий болгох, босоо мод унагаахаас сэргийлэх, иргэдэд хэрэглээний модыг бэлтгэн нийлүүлэх	100 биелсэн	25.0 сая	15.0 сая

Төслийн тайлан мэдээг хавар болон намар төсөл хэрэгжүүлсэн хугацааны биелэлтийг гаргаж Байгаль орчны байцаагч болон сумын Засаг даргын Тамгын газарт тайлагнаж ажилласан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Бүрэгхангай сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Энхтөр гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, газрын захирал, тэргүүлэх аудитор Б.Эрдэнэ нар тус тус хэрэгжүүлсэн.

Бүрэгхангай сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 03/43 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны санхүүжилтийн дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүжилтийн дүнгийн 710.2 сая төгрөгөөс 80 хувиар буюу 5.7 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага алба хаагчдын хурал цуглаан, сургалт семинарыг цахимаар зохион байгуулж үүнээс албан томилолтын зардлаас 1.2 сая, шатахууны зардлыг өмнөх онтой харьцуулахад 3.3 сая төгрөгийг хэмнэж ажиллажээ.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд 2022 онд 7 мэдээлэл хугацаа хоцроож хуулийн хугацаанд бүрэн мэдээлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагын жилийн эцсийн төвлөрүүлсэн орлогыг санхүүгийн тайланд данс андуурч бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу залруулах бичилтийг хийлээ.

Шийдвэрлэсэн нь:

Алдааг залруулав.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай /бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт/ нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Бүрэгхангай сумын Засаг даргын Тамгын газрын санхүүгийн тайланд завсарын аудит хийгээгүй болно.

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Бүрэгхангай сумын Засаг даргын Тамгын газар нь 2022 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн 03/313 тоот албан бичгээр акт, зөвлөмжийн хэрэгжилтийн биелэлтийг хүргүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	0	0	0	0	0
Албан шаардлага	1	950,575.8	1	950,575.8	100
Зөвлөмж	0	0	0	0	0
Нийт дүн	1	950,575.8	1	950,575.8	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Анхан шатны баримтын бүрдлийг шалгаж санхүүгийн тайланд тусгах, томилолтын зардлыг зориулалт бусаар зарцуулахгүй байх, Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 55.3 сая төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 55.3 сая төгрөгийн алдааг залрууллаа.

Үүнд: Тус байгууллагын жилийн эцсийн төвлөрүүлсэн орлогыг санхүүгийн тайланд данс андуурч бүртгэсэн

5.1 Төлбөрийн акт

Томилолтын зардлаас 198.0 мянган төгрөгийг зарцуулсан боловч томилолтын хуудсыг цаад газраар хаалгаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дах "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтыг зөрчсөн байна.

5.2 Албан шаардлага

Албан шаардлага бичигдээгүй болно.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Шилэн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: /Нөхцөл байдал, үр дагавар, нийцээгүй хууль тогтоомж, стандартын заалтыг бичих/

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

Шилэн дансны 7 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэсэн заалтыг мөрдөж ажиллаагүй.

Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэсэн заалтыг мөрдөж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/ Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
жилийн эцсийн төвлөрүүлсэн орлогыг санхүүгийн тайланд данс андуурч бүртгэсэн	1	55,328.5			1	55,328.5	1	55,328.5				
Дүн	1	55,328.5			1	55,328.5	1	55,328.5				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		/мянган төгрөгөөр/ Үүнээс		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
									Хариуцлага тооцуулах албан шаардлага	Албан тушаалтны тоо		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бүрэгхангай сумын ЗДТГ	2	198.0	1	198.0			1	0				
Дүн	2	198.0	1	198.0			1	0				